



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 1/120

Мөрөн сум

Г Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх Г
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг сумын хэмжээний бүх хонь, хургыг хамруулан 2024 оны 08 дугаар сарын 05 өдрөөс 20 хоног шуурхай зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг технологит хугацаанд нь гүйцэтгэх, уг ажлын чанар, явц гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж ажиллахыг багийн Засаг Дарга нарт даалгасугай.

3. Малчдад урьдчилан мэдэгдэж, тарилгын хашаа хоолой бэлдүүлэх, урьдчилан сэргийлэх тарилгад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг ханган ажиллахыг Засаг Даргын орлогч (Б.Мягмаржав)-д үүрэг болгосугай.

4. Урьдчилан сэргийлэх тарилгад график хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн иргэн, албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Т.Жавхлантөгс)-д үүрэг болгосугай.

5. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжийг хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн (Т.Жавхлантөгс)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ц.БАТЦООЖ

C:\My Documents\ZAXIRAMZI.doc

234002120